

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/8/НА-СТА-ТТ3

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас: 261740 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5
2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
2.5 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	7
2.6 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	13
3.5.2 Авлага	13
3.5.3 БАРАА МАТЕРИАЛ	14
3.5.4 Үндсэн хөрөнгө	15
3.5.5 ӨР ТӨЛБӨР	16
3.5.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт	17
3.6.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт	18
3.6.3 Төсвийн гүйцэтгэл	18
3.6.4 Нэмэлт төсөв	19
3.6.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	22
4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	22
4.5.1 ЗАВСРЫН АУДИТЫН ТАЛААР	22
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	23
4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	26
6.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДААНЫ НЭГТГЭЛ	26
6.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	27
6.3 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АА	Ажлын алба
ЗГ	Засгийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДГ	Нийгмийн даатгалын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 802
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэмэлт санхүүжилтээр Засаг даргын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан 1,788.0 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 81.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 351.6 сая төгрөг, нийт 2,220.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,218.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Ай Ти Зон” ХХК-иар гүйцэтгүүлсэн Нийгмийн даатгалын мэдээллийн “Sicos” системийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв бүрэн хүлээн авч, цаашид системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хариуцахаар болжээ.

Тайлант онд тус системийн сайжруулалт, хөгжүүлэлттэй холбоотой лиценз худалдан авахад “Ай Ти Зон” ХХК-иар дамжуулан нийт 2,707.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардлаас зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар “2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн орон тооны төлөвлөгөөг” батлан уг төлөвлөгөөнд сайн дурын даатгалд нийт 199,700 даатгуулагч, үүнээс 26,900 даатгуулагчийг шинээр хамруулахаар тусгаж, гүйцэтгэлээр хүрэх түвшнээс 85.7 хувь буюу 23,100 иргэнийг шинээр сайн дурын даатгалд, нийт хамрагдвал зохих малчдыг тоог 125.6 хувь буюу 10,700 иргэнээр нэмэгдүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Ө.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,261,732.2	1,022,272.4
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,471.8	-
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	8,583.8	20,239.2
4	УРЬДЧИЛГАА	7а, 7б	1,500.0	-
5	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,228,576.7	1,002,033.1
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	21,600.0	-
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	33,184,280.3	39,208,845.9
8	Биет хөрөнгө		31,486,139.2	31,975,051.4
9	Биет бус хөрөнгө	13	1,698,141.1	7,233,794.5
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		34,446,012.6	40,231,118.3
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР		14,766.4	92,370.0
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		14,766.4	92,370.0
13	Өглөг		14,766.4	92,370.0
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		34,431,246.2	40,138,748.2
15	Засгийн газрын оруулсан капитал		12,216,142.7	12,216,142.7
16	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		17,795,780.9	23,503,283.0
17	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,419,322.6	4,419,322.6
18	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		34,446,012.6	40,231,118.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		102,919,288.6	75,605,764.6
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	37,300,158.1	75,605,764.6
3	Нийтлэг татварын бус орлого		37,300,158.1	6,774,718.7
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		65,619,130.5	-
5	Улсын төвлөрсөн төсвөөс		63,363,208.1	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	68,390,625.5	69,824,551.5
7	УРСГАЛ ЗАРДАЛ		68,390,625.5	69,824,551.5
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		60,130,202.4	63,859,363.2
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		46,063,991.5	50,531,977.7
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		5,594,850.6	6,153,204.2
11	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,410,237.0	1,475,857.3
12	Хангамж, бараа материалын зардал		1,218,941.7	719,539.6
13	Эд хогшил, урсгал засварын зардал		527,892.2	165,492.1
14	Томилолт, зочны зардал		621,668.5	265,675.8
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,207,225.0	991,415.1
16	Бараа үйлчилгээний бусад зардал		3,485,395.9	3,556,201.5
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,260,423.1	5,965,188.3
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		34,528,663.1	5,781,213.1
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		28,658.7	52,083.1
20	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(28,658.7)	(52,083.1)
21	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		34,500,004.4	5,729,130.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(68,758.2)	-	(68,758.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(68,758.2)	-	(68,758.2)
4	Тайлант үеийн үр дүн	34,500,004.4	-	34,500,004.4
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,431,246.2	-	34,431,246.2
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(21,627.9)	-	(21,627.9)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,409,618.3	-	34,409,618.3
9	Тайлант үеийн үр дүн	5,729,130.0	-	5,729,130.0
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	40,138,748.2	-	40,138,748.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	65,622,884.2	68,956,160.6
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,148.4	68,956,160.6
3	Нийтлэг татварын бус орлого	63,148.4	125,114.8
4	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,559,735.8	-
5	Улсын төвлөрсөн төсвөөс	63,363,208.1	-
6	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,064,955.8	66,167,669.8
7	УРСГАЛ ЗАРДАЛ	65,064,955.8	66,167,669.8
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,782,270.5	60,216,709.2
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,098,645.7	50,538,954.6
10	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,586,284.9	6,157,825.5
11	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,410,210.5	1,455,059.3
12	Хангамж, бараа материалын зардал	870,251.3	546,794.8
13	Эд хогшил, урсгал засварын зардал	773,815.9	131,563.1
14	Томилолт, зочны зардал	560,439.6	265,675.8
15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,238,613.0	955,112.6
16	Бараа үйлчилгээний бусад зардал	244,009.6	165,723.4
17	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,282,685.3	5,950,960.7
18	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	557,928.5	2,788,490.8
19	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	541,084.8	2,789,962.6
20	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	541,084.8	2,789,962.6
21	Дотоод эх үүсвэрээр	541,084.8	2,789,962.6
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(541,084.8)	(2,789,962.6)
23	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(15,371.8)	-
24	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,471.8	(1,471.8)
25	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,471.8
26	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,471.8	-

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	67,377,496,300.00	62,782,957,540.57	4,594,538,759.43	93.2
12	Татварын бус орлого	67,377,496,300.00	62,782,957,540.57	4,594,538,759.43	93.2
120	Нийтлэг татварын бус орлого	-	31,128,198.00	(31,128,198.00)	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	31,128,198.00	(31,128,198.00)	
122	Тусламжийн орлого	67,377,496,300.00	62,751,829,342.57	4,625,666,957.43	93.1
122005	Төсвөөс санхүүжих	67,377,496,300.00	62,751,829,342.57	4,625,666,957.43	93.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,377,496,300.00	62,782,957,540.57	4,594,538,759.43	93.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,377,496,300.00	62,782,957,540.57	4,594,538,759.43	93.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,222,611,400.00	60,701,553,219.84	4,521,058,180.16	93.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,684,945,500.00	48,726,491,742.56	2,958,453,757.44	94.3
210101	Үндсэн цалин	26,227,466,400.00	25,791,392,467.83	436,073,932.17	98.3
210102	Нэмэгдэл	14,905,280,900.00	13,400,900,718.95	1,504,380,181.05	89.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,163,183,900.00	4,785,396,877.05	377,787,022.95	92.7
210104	Урамшуулал	5,389,014,300.00	4,748,801,678.73	640,212,621.27	88.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,644,103,900.00	5,935,824,749.01	708,279,150.99	89.3
210201	Тэтгэврийн даатгал	4,520,822,000.00	4,111,604,498.80	409,217,501.20	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	538,950,400.00	482,082,739.52	56,867,660.48	89.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	265,539,800.00	242,607,400.70	22,932,399.30	91.4
210204	Ажилгүйдлийн даатгал	263,425,800.00	216,365,156.92	47,060,643.08	82.1
210205	Эрүүл мэндийн даатгал	1,055,365,900.00	883,164,953.07	172,200,946.93	83.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,712,590,000.00	1,455,059,279.86	257,530,720.14	85.0
210301	Гэрэл, цахилгаан	415,557,400.00	318,059,846.78	97,497,553.22	76.5
210302	Түлш, халаалт	1,107,312,500.00	987,699,060.82	119,613,439.18	89.2
210303	Цэвэр, бохир ус	143,769,400.00	107,492,664.31	36,276,735.69	74.8
210304	Байрны түрээс	45,950,700.00	41,807,707.95	4,142,992.05	91.0
2104	Хангамж, бараа материалын зардал	593,107,300.00	470,996,146.36	122,111,153.64	79.4
210401	Бичиг хэрэг	192,832,700.00	161,799,279.00	31,033,421.00	83.9
210402	Тээвэр, шатахуун	32,792,800.00	28,508,265.14	4,284,534.86	86.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,951,300.00	112,942,217.50	46,009,082.50	71.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,037,700.00	17,864,284.00	9,173,416.00	66.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	181,492,800.00	149,882,100.72	31,610,699.28	82.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	134,413,200.00	122,672,130.00	11,741,070.00	91.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,066,700.00	20,066,650.00	50.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,112,800.00	14,178,600.00	11,934,200.00	54.3
210604	Урсгал засвар	88,233,700.00	88,426,880.00	(193,180.00)	100.2
2107	Томилолт, зочны зардал	335,037,900.00	261,325,750.00	73,712,150.00	78.0
210702	Дотоод албан томилолт	335,037,900.00	261,325,750.00	73,712,150.00	78.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,053,039,400.00	3,684,964,990.05	368,074,409.95	90.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	366,009,800.00	250,473,351.00	115,536,449.00	68.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	155,152,100.00	74,032,900.00	81,119,200.00	47.7
210803	Даатгалын үйлчилгээ	26,474,700.00	14,021,886.00	12,452,814.00	53.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,089,800.00	6,288,700.00	4,801,100.00	56.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,440,806,800.00	3,308,049,493.45	132,757,306.55	96.1
210807	Газрын төлбөр	9,241,600.00	6,910,512.00	2,331,088.00	74.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,807,200.00	7,469,717.60	18,337,482.40	28.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,457,400.00	17,718,430.00	738,970.00	96.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,374,200.00	44,218,432.00	21,155,768.00	67.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,374,200.00	44,218,432.00	21,155,768.00	67.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,154,884,900.00	2,081,404,320.73	73,480,579.27	96.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,154,884,900.00	2,081,404,320.73	73,480,579.27	96.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	305,072,600.00	260,280,786.00	44,791,814.00	85.3

**Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,407,259,500.00	1,394,895,378.91	12,364,121.09	99.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	442,552,800.00	426,228,155.82	16,324,644.18	96.3
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	522,835.01	(522,835.01)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,757	2,653	104	96.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	100.0
610001	Төсвийн байгууллага	33	33	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,341	1,292	49	96.3
620001	Удирдах ажилтан	155	142	13	91.6
620002	Гүйцэтгэх ажилтан	1,186	1,150	36	97.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,341	1,292	49	96.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,104	1,071	33	97.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	9	9	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	118	212	(94)	179.7
650014	Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	110	-	110	-
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	42	36	6	85.7
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	42	36	6	85.7

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,220,549,231.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,220,549,231.49
122	Тусламжийн орлого	2,220,549,231.49
1221	Хандив тусламж /дотоод/	2,220,549,231.49
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,220,549,231.49
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,974,610.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,787,929,154.13
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	351,645,467.36
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,218,089,024.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,218,089,024.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,215,089,024.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,812,462,877.85
210101	Үндсэн цалин	446,181.00
210102	Нэмэгдэл	1,588,669,486.81
210104	Урамшуулал	223,347,210.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,000,776.04
210201	Тэтгэврийн даатгал	158,483,218.76
210202	Тэтгэмжийн даатгал	16,318,599.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,446,296.03
210204	Ажилгүйдлийн даатгал	7,764,171.97
210205	Эрүүл мэндийн даатгал	30,988,489.55
2104	Хангамж, бараа материалын зардал	75,798,690.00
210401	Бичиг хэрэг	360,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,885,000.00
210404	Ном, хэвлэл	57,354,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,199,480.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,346,181.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,020,400.00
210604	Урсгал засвар	18,325,781.00
2107	Томилолт, зочны зардал	4,350,000.00
210702	Дотоод албан томилолт	4,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,655,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,655,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,475,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,975,331.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,500,169.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,460,206.60
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,460,206.60)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,460,206.60)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагч нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвөөс олгох хөрөнгө, нийгмийн даатгалын сангуудын зарлага, санхүүжилтийн талаар санхүүгийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн сан, банкттай ажлаа уялдуулан мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын төвлөрсөн санд улсын төсвөөс шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын санд цаг тухайд нь шилжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;
- Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр, мэдээг сар бүр гаргаж, санал, дүгнэлтийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж, танилцуулах;
- Ажил олгогч, даатгуулагчаас шимтгэлийг бүрэн төлүүлэх, тооцоо хийх, бүртгэлд тусгах, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг зохих журмын дагуу шуурхай олгох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Нийгмийн даатгалын байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас ажил олгогч, даатгуулагчийн гаргасан зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;
- Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх, эсхүл эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаанд хяналт тавьж, эрүүл мэндийн магадлалын үйлчилгээг удирдан зохион байгуулж шалган зааварлах;
- Эрдэм шинжилгээ, боловсрол, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
- НДЕГ-ын болон бүсийн төвийн аймгийн нийгмийн даатгалын байгууллагын нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг тасралтгүй сургах;
- Нийгмийн даатгалын байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээгээр хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг өргөжүүлэх, цахим тооцоолох техник хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 41 дүгээр зүйлд заасан ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран улсын хэмжээнд зохион байгуулах;
- Гадаад улстай байгуулсан нийгмийн даатгалын талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Даатгуулагч, хүн, ажил олгогчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгож, үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- “Төрөөс хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих” өдөрлөгийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран зохион байгуулж, уг өдөрлөг хувийн хэвшилд дутагдалтай байгаа ажиллах хүчний хэрэгцээг хангах, төрийн албанаас хувийн хэвшилд шилжин ажиллах, төрийн албан хаагчдын хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготойгоор анх удаа зохион байгуулагдсан байна. Өдөрлөгт 22 аж ахуйн нэгж, байгууллага оролцож,

1,117 ажлын байр бэлэн байгааг төрийн албан хаагчдад танилцуулсан бөгөөд 300 орчим төрийн албан хаагч, иргэд оролцсон байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий газраас шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой үйл ажиллагааг дэмжих, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгоход хамтран ажиллах зорилго бүхий “Итгэлцлийн аян”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд 1 сарын хугацаанд зохион байгуулсан байна. Итгэлцлийн аянд нийтдээ 19,400 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна.
- НДЕГ, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн Танхимтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна. Санамж бичгийг байгуулснаар талууд Нийгмийн даатгалын багц хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, бизнес эрхлэгч ажил олгогч, нийгмийн даатгалд даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хамтарч ажиллахаар болсон байна.
- НДЕГ Монгол Улсаас Унгар Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Унгар Улсад оршин суугаа иргэдэд нийгмийн хамгаалал, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлаар цахимаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. Мөн хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх боломжийн талаар мэдээлэл өгөх цахим уулзалтыг тогтмол зохион байгуулж байхаар төлөвлөн ажилласан байна.
- Нийгмийн даатгалын байгууллага 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласан байна. Энэ зорилтын хүрээнд Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан байна.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Өмгөөллийн цэгц хүч” ХХН-тэй хамтран “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг журам” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтад төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох чиг үүргийн албан хаагчид танхим болон цахимаар оролцсон байна.
- НДЕГ-ын даргын 2025 оны “Заавар батлах тухай” А/267 дугаар тушаалаар “Тэтгэмж бодох заавар”-ыг батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яам 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7,399 дугаарт бүртгэсэнтэй холбогдуулан уг зааврыг хэрэгжүүлэх арга зүй, анхаарах асуудлын талаарх сургалтыг цахимаар зохион байгуулж, сургалтад 21 аймаг, 9 дүүргийн Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, тэтгэмжийн тогтоолт олголтын байцаагч мэргэжилтэн, магадлагч эмч мэргэжилтнүүд нийт 94 ажилтан албан хаагч оролцож, зааврыг хэрэгжүүлэхэд анхаарах гол асуудлууд, арга зүй, зөвлөмж өгч ажилласан байна.

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Олон улсын хэлэлцээр болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/172 дугаар тушаал;
- Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврууд гаргасан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

НДЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.4, 6.5-д заасны дагуу хяналт-шинжилгээ хийж, тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилт, 69 арга хэмжээ тусгаснаас хэрэгжилтийг 92.1 хувь гэж үнэлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НДЕГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/362 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад нийцсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 40,231.1 сая төгрөг болж өмнөх оноос 5,785.1 сая төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,471.8	-	(1,471.8)
Авлага	8,583.8	20,239.2	11,655.5
Урьдчилгаа	1,500.0	-	(1,500.0)
Бараа материал	1,228,576.7	1,002,033.1	(226,543.5)
Үндсэн хөрөнгө	33,184,280.3	39,208,845.9	6,024,565.6
Нийт хөрөнгө	34,446,012.6	40,231,118.3	5,785,105.7
Өглөг	14,766.4	92,370.0	77,603.6
Засгийн газрын оруулсан капитал	12,216,142.7	12,216,142.7	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	34,446,012.6	40,231,118.3	5,785,105.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна. Тухайлбал:

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй гарсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,471.8	-	(1,471.8)
Төрийн сангийн харилцах	1,471.8	-	(1,471.8)
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	1,471.8	-	(1,471.8)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр буурсан нь Ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг тайлант оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: НДЕГ-ын харьяа байгууллагуудад мөнгөн хөрөнгө данстай холбоотой нийт 405.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 143.3 сая төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан. /Өмнөговь аймгийн НДГ 69.0 сая төгрөг, Увс аймгийн НДГ 29.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн НДГ 16.7 сая төгрөг, НДЕГ 14.4 сая төгрөг, Булган аймгийн НДГ 0.7 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн НДГ 8.7 сая төгрөг, Багануур дүүргийн НДГ 3.8 сая төгрөг/
- Албан хаагчдад 107.9 сая төгрөгийн цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан. /Чингэлтэй дүүргийн НДГ 46.3 сая төгрөг, Дорнод аймгийн НДГ 23.8 сая төгрөг, Говь-Алтай аймгийн НДГ 10.6 сая төгрөг, Орхон аймгийн НДГ 7.1 сая төгрөг, Булган аймгийн НДГ 6.4 сая төгрөг, Увс аймгийн НДГ 3.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн НДГ 2.8 сая төгрөг, НДҮЗ-ийн АА 2.7 сая төгрөг, Хан-Уул дүүргийн НДГ 2.4 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн НДГ 1.8 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн НДГ 0.8 сая төгрөг, НДЕГ-ын дэргэдэх МТТ 0.2 сая төгрөг/
- Батлагдсан төсвийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулаагүй 100.0 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон, 3.0 сая төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан. /НДЕГ/
- Туслах үйл ажиллагааны 22.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлээгүй. /Налайх дүүргийн НДГ/
- Байгууллагын дансанд төвлөрүүлсэн 32.0 сая төгрөгийн орлогын дансны бичилтийг буруу хийж зардлыг бууруулан тайлагнасан. /Чингэлтэй дүүргийн НДГ/

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 20.2 сая төгрөг болж өмнөх оноос 11.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,322.7	7,976.8	5,654.1
Татаас, санхүүжилтийн авлага	-	629.4	629.4
Байгууллагаас авах авлага	5,444.4	10,816.3	5,372.0
Хувь хүмүүсээс авах авлага	816.7	816.7	-
Дүн	8,583.8	20,239.2	11,655.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 53.4 хувь буюу 10.8 сая төгрөгийг байгууллагаас авах авлага, 39.4 хувь буюу 8.0 сая төгрөгийг ажиллагсдаас авах авлага, 4.0 хувь буюу 0.8 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага, 3.1 хувь буюу 0.6 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлага тус тус эзэлж байна.

Байгууллагаас авах авлага дансны үлдэгдэл 11 аймгийн, дүүргийн НДГ, болон НДЕГ-ын нийт 10.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Тухайлбал:

- Архангай аймгийн НДГ нь 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь албан хаагчдад тооцож олгох орон нутгийн болон хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг зөрүүтэй тооцож, илүү шилжүүлсэн НДШ-ийн авлага 2.4 сая төгрөг, цалингаас суутгасан татвар 0.5 сая төгрөгийн илүү төлөлттэй холбоотой,
- Хөвсгөл аймгийн НДГ нь 1.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь ХХОАТ болон НДШ-тэй холбоотой;
- Орхон аймгийн НДГ нь 0.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь нэг удаагийн тэтгэмжээс татвар суутгасантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад авлагын данстай холбоотой нийт 14.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд НДШ-ийг 5.0 сая төгрөгөөр, ХХОАТ-ыг 9.8 сая төгрөгөөр илүү шилжүүлж, татвар, нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага үүсгэсэн. /Архангай аймгийн НДГ 2.9 сая төгрөг, Багахангай дүүргийн НДГ 9.0 сая төгрөг, Баянзүрх дүүргийн НДГ 2.8 сая төгрөг/

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,002.0 сая төгрөг болж, өмнөх оноос 226.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	130,604.3	75,960.8	(54,643.4)
Аж ахуйн материал	634,813.9	601,858.7	(32,955.2)
Сэлбэг хэрэгсэл	300,264.5	224,662.2	(75,602.3)
Түлш, шатах тослох материал	8,156.2	1,549.7	(6,606.5)
Барилгын засварын материал	25,599.5	19,710.7	(5,888.9)
Бусад хангамжийн материал	129,138.3	78,291.0	(50,847.4)
Дүн	1,228,576.7	1,002,033.1	(226,543.5)

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 601.9 сая төгрөг буюу 60.1 хувийг аж ахуйн материал, 224.7 сая төгрөг буюу 22.4 хувийг сэлбэг хэрэгсэл, 76.0 сая төгрөг буюу 7.6 хувийг бичиг хэргийн материал, 78.3 сая төгрөг буюу 7.7 хувийг бусад хангамжийн материал, 19.7 сая төгрөг буюу 2.0 хувийг барилгын засварын материал, 1.5 сая төгрөг буюу 0.2 хувийг түлш, шатах тослох материал тус тус эзэлж байна.

Тайлант онд бараа материалын худалдан авалт 518.3 сая төгрөг, шилжүүлэн авч бүртгэсэн 47.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 669.1 сая төгрөгийг зарцуулж, НДЕГ-ын 2025 оны А/354 дүгээр “Бараа материал акталж, данснаас хасах тухай” тушаалын дагуу 40.7 сая төгрөгийн бараа материалыг акталж, 82.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Бараа материалын үлдэгдэл буурахад бичиг хэргийн материал 54.6 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 75.6 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 50.8 сая төгрөгөөр, аж ахуйн материал 33.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад бараа материалын данстай холбоотой нийт 3.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Биет бус хөрөнгийн шинж чанартай 3.8 сая төгрөгийн үнэ бүхий программ, хангамжийг бараа материалын дансанд бүртгэсэн. /Сүхбаатар дүүргийн НДГ 3.8 сая төгрөг/

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 39,208.8 сая төгрөг болж, өмнөх оноос 6,024.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	31,486,139.2	31,975,051.4	488,912.2
Барилга, байгууламж, орон сууц	26,649,159.0	26,296,588.2	(352,570.8)
Авто-тээврийн хэрэгсэл	284,612.7	179,548.5	(105,064.2)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,762,085.3	4,847,438.1	1,085,352.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	779,990.9	642,935.2	(137,055.7)
Бусад үндсэн хөрөнгө	6,803.3	5,053.3	(1,750.0)
Дуусаагүй барилга, байгууламж	3,488.0	3,488.0	-
Биет бус хөрөнгө	1,698,141.1	7,233,794.5	5,535,653.4
Програм хангамж	538,549.5	6,049,492.8	5,510,943.3
Бусад биет бус хөрөнгө	1,159,591.6	1,184,301.7	24,710.1
Дүн	33,184,280.3	39,208,845.9	6,024,565.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 67.1 хувь буюу 26,296.6 сая төгрөгийг барилга, байгууламж, 12.4 хувь буюу 4,847.4 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, 1.6 хувь буюу 642.9 сая төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил, 15.4 хувь буюу 6,049.5 сая төгрөгийн программ хангамж, 0.5 хувь буюу 179.5 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 0.01 хувь буюу 5.1 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 0.01 хувь буюу 3.5 сая төгрөгийн дуусаагүй барилга, байгууламж тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө данстай холбоотой дараах шийдвэрүүдийн дагуу өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2025 оны 284,730 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 109 нэр төрлийн нийт 171.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг 71.5 сая төгрөгөөр, 569 нэр төрлийн нийт 5,342.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,208.2 сая төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон;
- ТӨБЗГ-ын 2025 оны А1/2106 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 33 нэр төрлийн нийт 16.4 сая төгрөгийн балансын үнэ, 7.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг харьяа байгууллагад балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 530 дугаар тогтоолоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 327 дугаартай магадлалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй, 7,408 м.кв газар эзэмших эрхийг 4,309 м.кв болгосонтой холбогдуулан үнэлгээг 2,739 м.кв талбайн үнэлгээ болох 16.1 сая төгрөгөөр бууруулан данснаас хасаж бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 600, 893 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газар, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 374 нэр төрлийн нийт 566.4 сая төгрөгийн балансын үнэ, 565.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 407 нэр төрлийн нийт 483.0 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас тус тус хасалт хийсэн;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөрөнгийн хуваарилалт батлах тухай” 2025 оны А/131, А/146 дүгээр тушаалаар салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж төсөл арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарилагдсан нийт 728.6 сая төгрөгийн үнэ бүхий 7 серверийн тоног төхөөрөмжийг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн нийт 114.8 сая төгрөгийн үнэ бүхий 40 ширхэг компьютер, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд тус тус бүртгэсэн;

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2025 оны А/209 дугаар тушаалаар нийт 48.8 сая төгрөгийн 45 ширхэг бүртгэсэн компьютер, тоног төхөөрөмжийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 198.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, дахин үнэлгээ хийгдээгүй 88.3 сая төгрөгийн үндсэн болон биет бус хөрөнгө бүртгэлтэй байна. /Дундговь аймгийн НДГ 56.3 сая төгрөг, Төв аймгийн НДГ 32.0 сая төгрөг/;
- Балансаас балансад шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийн элэгдлийг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ орлого дансыг 0.2 сая төгрөгөөр бууруулж бүртгэсэн. /Налайх дүүргийн НДГ 0.2 сая төгрөг/;
- Санхүүгийн тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний нөөц үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 55.3 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн. /Багануур дүүргийн НДГ 22.4 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн НДГ 32.9 сая төгрөг/;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг алдаатай тооцсон, дээд байгууллагаас шилжиж ирсэн 54.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих журам, стандартын дагуу бүртгээгүй. /Сонгинохайрхан дүүргийн НДГ 25.0 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн НДГ 4.6 сая төгрөг, Хан-Уул дүүргийн НДГ 0.1 сая төгрөг, Орхон аймгийн НДГ 25.0 сая төгрөг/;
- Эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомж, зааврын дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй, тооллогын бүртгэл хөтлөөгүй, өмч хамгаалах зөвлөл хөрөнгийн асуудлыг хэлэлцсэн талаарх тэмдэглэл хөтлөөгүй. /Говьсүмбэр аймгийн НДГ/.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 92.4 сая төгрөг болж, өмнөх оноос 77.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	3,091.9	7,046.8	3,954.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,411.5	78,406.6	72,995.1
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	50.0	50.0	-
Байгууллагад төлөх өглөг	6,213.0	6,842.4	629.4
Хувь хүмүүст төлөх өглөг	-	24.3	24.3
Дүн	14,766.4	92,370.0	77,603.6

Эх сурвалж: НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн 7.4 хувь буюу 6.8 сая төгрөгийг байгууллагад төлөх өглөг, 84.8 хувь буюу 78.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлын өглөг, 7.6 хувь буюу 7.0 сая төгрөгийг ажилчидтай холбогдсон өглөг, 0.05 хувь буюу 0.1 сая төгрөгийн татаас санхүүжилтийн өглөг, 0.03 хувь буюу 0.02 сая төгрөгийг хувь хүмүүст төлөх өглөг тус тус эзэлж байна.

Нийт өглөгийн 84.8 хувь буюу 78.4 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг эзэлж байгаа нь харьяа 24 аймаг, дүүргийн байр ашиглалттай холбоотой гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр, бохир, ус, шуудан холбооны өглөг, өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээ, тээврийн хэрэгслийн даатгалын зардлын өглөг эзэлж байна. /ГАА-ын НДГ 12.0 сая төгрөг, НД-ийн НДГ 10.5 сая төгрөг, ДоА-ын НДГ 8.2, СБД-ийн НДГ 8.0 сая төгрөг, БНД-ийн НДГ 6.8 сая төгрөг, УВА-ын НДГ 5.4 сая төгрөг, СХД-ийн НДГ 4.9 сая төгрөг, ХоА-ын НДГ 3.2 сая төгрөг, БУА-ын НДГ 2.7 сая төгрөг, ОРА-ын НДГ 2.5 сая төгрөг, БХА-ын НДГ 2.1 сая төгрөг, БӨА-ын НДГ 2.0 сая төгрөг, ДАА-ын НДГ 2.0 сая төгрөг, ГСА-ын НДГ 1.6 сая төгрөг, БЗД-ийн НДГ 1.6 сая төгрөг, БГД-ийн НДГ 1.1 сая төгрөг, ТӨА-ын НДГ 0.8 сая төгрөг, СҮА-ын НДГ 0.6 сая төгрөг, ЗАА-ын НДГ 0.3 сая төгрөг, ЧД-ийн НДГ 0.2 сая төгрөг, ДОА-ын НДГ 0.1 сая төгрөг, БХД-ийн НДГ 0.05 сая төгрөг/

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад өр төлбөрийн данстай холбоотой нийт 15.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Харилцагчийн 15.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /Сүхбаатар дүүргийн НДГ 15.3 сая төгрөг/;

- Чингэлтэй дүүргийн НДГ нь ЦХТАОСТ-ын өглөгийг 0.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 40,138.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,707.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	12,216,142.7	12,216,142.7	-
Хуримтлагдсан үр дүн	17,795,780.9	23,503,283.0	5,707,502.0
Өмнөх үеийн үр дүн	(16,704,223.5)	17,774,153.0	34,478,376.5
Тайлант үеийн үр дүн	34,500,004.4	5,729,130.0	(28,770,874.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419,322.6	4,419,322.6	-
Дүн	34,431,246.2	40,138,748.2	5,707,502.0

Эх сурвалж: НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцооны 58.6 хувь буюу 23,503.3 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүн, 30.4 хувь буюу 12,216.1 сая төгрөгийн засгийн газрын оруулсан капитал, 11.0 хувь буюу 4,419.3 сая төгрөгийг хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү эзэлж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд НДЕГ-ын төвлөрүүлэн захирагчийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 65,131.8 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлыг 65,131.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1528 дугаар албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд НДЕГ-ын төвлөрүүлэн захирагчийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс үйл ажиллагааны урсгал зардлыг 7,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 75,089.0 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор нийт зардлыг 7,711.5 сая төгрөгөөр бууруулж, 67,377.5 сая төгрөгөөр батлагдсан байна. Тухайлбал:

- Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 2,647.4 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 208.2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 35.5 сая төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 155.0 сая төгрөг;
- Албан томилолт, зочны зардлыг 45.6 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,069.5 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид Нийгмийн даатгалын байгууллагуудын шаардагдах төсвийг шийдвэрлэхээр 2025 оны батлагдсан төсөвт 9 удаагийн хуваарийн өөрчлөлт хийх саналыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхэд нийт 67,377.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс урсгал зардлын бараа, ажил үйлчилгээний зардалд 65,222.6 сая төгрөг, тэтгэмж урамшууллын зардлын санхүүжилтэд 2,154.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

3.6.2 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Туслах үйл ажиллагааны орлого буюу байгууллагын эзэмшлийн байрны түрээсийн орлогоос 31.1 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээнд нийт 67,377.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 62,782.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 62,783.0 сая төгрөг буюу 93.2 хувь байгаа нь цалин, хөлсний зардлыг 2,958.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 257.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 11.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 122.1 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 73.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 368.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 21.2 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 73.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр арга, хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
	Код	Нэр				
Нийт дүн			67,377,496.3	62,782,957.5	4,594,538.8	93.2
1	71901	Нийгмийн даатгал	67,377,496.3	62,782,957.5	4,594,538.8	93.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	62,100,144.3	58,607,349.1	3,492,795.2	94.4
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	199,155.7	137,780.5	61,375.2	69.2
1.3	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээ	225,597.6	148,304.2	77,293.4	65.7
1.4	80219	Харуул хамгаалалтын зардал	140,412.2	102,169.2	38,243.0	72.8
1.5	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	2,557,301.6	1,705,950.3	851,351.3	66.7
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,849,812.3	1,821,123.5	28,688.8	98.4
1.7	80813	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох нөхөн олговор	192,146.1	162,318.4	29,827.7	84.5
1.8	80820	Бусад тусламж, дэмжлэг	112,926.5	97,962.4	14,964.1	86.7

Эх сурвалж: НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар: Монгол Улсын Их Хурлын баталсан 2024 оны “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” заалт, “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг тайлант онд эхлүүлсэн.

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор НДЕГ-ын орон тооны хязгаарыг 93 байсныг 9.7 хувиар буюу 9 орон тоогоор бууруулж, 84 байхаар баталжээ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн

байгууллагын орон тооны дээд хязгаар, НДЕГ-ын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 2025 оны А/163 дугаар тушаалаар НДЕГ-ын нэгжийг 7 газар, 5 хэлтэстэй байсныг 6 газар, 5 хэлтэстэй байхаар баталсан байна.

НДЕГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/238 дугаар тушаалаар нийт орон тоог 399 болгон бууруулан баталж, өмнөх орон тооноос 9 орон тоо буюу цалингийн зардал 920.3 сая төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлээр 393 албан хаагчийн цалингийн зардалд 13,576.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

НДЕГ-ын даргын "Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 2025 оны А/239 дугаар тушаалаар нийт орон тоог 824 болгон бууруулан баталж, өмнөх орон тооноос 82 орон тоо буюу цалингийн зардал 2,088.0 сая төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлээр 764 албан хаагчийн цалингийн зардалд 23,966.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: НДЕГ-ын даргын “Албан хаагчдын унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2025 оны А/307 дугаар тушаалаар алба хаагчдын ажлын нөхөх төлбөрийн хэмжээг нэг өдөрт 35,000.00 төгрөгөөр (нэг өдрийн хоолны мөнгийг 34,000.00 төгрөг, унааны төлбөрийг 1,000.00 төгрөгөөр) баталжээ. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 4,439.1 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 4,106.8 сая төгрөгийг олгож, 332.4 сая төгрөгийг дутуу зарцуулсан, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад хоол, унааны зардал нийт 1,352.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Гадаад томилолт, арга хэмжээний талаар: Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал гараагүй байна.
- Сургалт, семинарын талаар: Тайлант онд 22 сургалт, семинарын зардалд 24.0 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 22 сургалт зохион байгуулахад 22.5 сая төгрөгийг зарцуулж, 1.2 сая төгрөгийн зардлыг дутуу зарцуулсан байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй байна.

3.6.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан 1,788.0 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 81.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 351.6 сая төгрөг нийт 2,220.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлснээс 2,218.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад өр төлбөрийн данстай холбоотой нийт 22.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр бэлтгэсэн 15.0 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн. /НДЕГ/
- Нэмэлт санхүүжилтийн зардлаас 7.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авалт хийж, шууд зардалд тайлагнасан. /Орхон аймгийн НДГ/

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

НДЕГ-ын тайлант онд худалдан авах ажиллагааны хүрээнд 5 багц бараа ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 3,229.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн гарын авлага, тараах материал хэвлэх, эх бэлтгэхэд 53.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар

- зохион байгуулж, “Адмон принт” ХХК шалгарч гэрээ байгуулан 10,000 ширхэг гарын авлага, 9,500 ширхэг багц хуулийн танилцуулга бүхий тараах материал хүлээн авч, гэрээний дагуу 30.7 сая төгрөгийг олгосон;
2. Нийгмийн даатгалын сангийн 149,133.8 сая төгрөгийн авлагыг барагдуулахтай холбоотой Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үйлчилгээ үзүүлэх 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 3 удаа зохион байгуулж, Дэлгэрэнгүй хууль НҮТББ-тай 198.0 сая төгрөгийн гэрээ байгуулан, гүйцэтгэлээр 121.8 сая төгрөгийг олгосон;
 3. Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай 79.2 сая төгрөгийн маягтын худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэлээр 17.7 сая төгрөгийг зарцуулсан;
 4. НДЕГ-ын байрны засварын 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулан, гүйцэтгэлээр 22.4 сая төгрөгийг зарцуулсан.
 5. Нийгмийн даатгалын өгөгдлийн сангийн удирдлагын лиценз, программ хангамж, системийн хөгжүүлэлт хийхэд нийт 2,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 удаа зохион байгуулж, шалгарсан “Ай Ти Зон” ХХК-тай мэдээллийн сангийн удирдлагын программ хангамжийн 2,319.0 сая төгрөгийн өртөг бүхий лиценз, аюулгүй байдлын мэдээлэл ба үйл явдлын удирдлагын программ хангамжийн 388.8 сая төгрөгийн өртөг бүхий лиценз нийлүүлэх гэрээ тус тус байгуулан, нийт 2,707.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

НДЕГ-ын Үнэлгээний хороо Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 13 удаа зохион байгуулж, үнэлгээний хорооны хурлыг нийт 40 удаа зохион байгуулсан байна. Тухайлбал:

- “Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйлчилгээ” үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын баримт бичгийг 3 удаа;
- “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн гарын авлага, танилцуулга хэвлүүлэх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль түүний ач холбогдлыг сурталчилсан маркетингийн бүтээгдэхүүн бэлтгэх, олон нийтэд түгээх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа;
- “Нийгмийн даатгалын өгөгдлийн сангийн удирдлагын программ хангамж, лиценз нийлүүлэх” тендер шалгаруулалтын баримт бичгийг 1 удаа тус тус боловсруулсан байсан.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 2,900.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mnd ил тодоор мэдээлээгүй. /Баянгол дүүргийн НДГ/

- НДЕГ нь 2,900.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн тайлагнаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн НДЕГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Үйл ажиллагааг сайжруулах болон дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал, Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлж ажилласан.

НДЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/652 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал 68,419.3 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 684.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 207.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 207.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй. /НДЕГ 206.9 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн НДГ 0.8 сая төгрөг/

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллагад нийцлийн аудиттай холбоотой 3,119.0 сая төгрөгийн 15 зөрчил илэрсэн үүнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,900.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, архивын нэгж бүрдүүлэхтэй холбоотой 1 албан шаардлага, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 206.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 835.9 сая төгрөгийн 4 зөвлөмж, мөн цалин хөлстэй холбоотой зөрчилд 10.7 сая төгрөгийн 2 зөвлөмж, худалдан авах ажиллагааг тайлагнаагүй зөрчилд 2 зөвлөмж, ахмадын сан байгуулж ажиллаагүй зөрчилд 3 зөвлөмж тус тус өгсөн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн Дотоод аудитын албанаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-д "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 37.13.5-д "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

НДЕГ-ын 2025 оны II улирлын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын тайланд хийсэн завсрын аудитаар нийт 10,624.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 3,133.4 сая төгрөгийн 7 алдааг залруулан, 7,491.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар 16 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Аймаг, хот, сумдад албан томилолтоор ажилласан хоногийг 8 албан хаагчид 1.4 сая төгрөгийн томилолтын олговрыг илүү тооцож олгосныг холбогдох албан хаагчдаас буцаан суутгасан байна.
- Бараа материалын дансанд өмнөх онд худалдан авсан нөөцлөх шаардлагагүй 23.5 сая төгрөгийн аж ахуйн материал буюу цайны материал, хугацаа дууссан ашиглалтгүй болсон маягт, зөвшөөрлийн хуудаснууд зарцуулагдаагүй үлдэгдлийг НДЕГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн баталсан "Бараа материал акталж, данснаас хасах тухай" А/351 дугаар тушаалаар данснаас хассан.

- Программ хангамжийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй болсон нэг бүр нь 0.1-0.7 сая төгрөгийн үнэ бүхий 7 төрлийн нийт 2,586.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын мэдээллийн системд дахин үнэлгээ хийгдээгүй, дахин ашиглах эсэх нь тодорхойгүй, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар арга хэмжээ авч шийдвэрлэсэн.
- Авто тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэй Toyota Land Cruiser 100 маркийн анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй болсон 17.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл ашиглалтгүй, төрийн албаны цэнхэр дугаар аваагүй, татварын зардалд 0.6 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоосон байна.
- Бараа материалын дансанд 3.0 сая төгрөгийн 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийн шинжтэй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэсэн байсныг залруулсан байна.
- Ажлын цагийн бүртгэлийн төхөөрөмж ашигладаггүй, цаасан хэлбэрээр албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хөтөлж байгаа нь Хөдөлмөрийн дотоод журмын 9.3 дахь заалттай нийцэхгүй байна. Үүнтэй холбоотой эхний хагас жилийн илүү цагийн хөлсийг цаг бүртгэлийн төхөөрөмжөөр баталгаажуулаагүй, сар бүр олголтгүй 2025 оны 6 дугаар сард бөөнд нь тооцож нийт 27.0 сая төгрөгийг нийт 8 албан хаагчид олгосон байна.
- Бараа материалын сэлбэг хэрэгслийн дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй нэг бүр нь 0.3-0.1 сая төгрөгийн үнэ бүхий канон, принтер, 50 инчийн зурагт, печь зэрэг нийт 5.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Завсрын аудитаар илэрсэн зөрчлөөс арилгах боломжгүй дараах зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Шагнах тухай" А/173 дугаар тушаалаар нэр бүхий 4 албан хаагчид 7.8 сая төгрөгийн шагналыг зардлын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Тайлант онд нягтлан бодогчид "санхүүгийн тайланг хугацаанд нь гаргасан" үндэслэлээр 2.4 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 920.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

1. Тайлант онд санхүүгийн тайланд 1,053 ширхэг 920.8 сая төгрөгийн машин, тоног, төхөөрөмж, тавилга эд хогшлыг ТӨБЗГ-ийн шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тайлагнасан зөрчлийг давтан гаргаагүй байна.
2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 35 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,139.8 сая төгрөгийн 105 алдаа, зөрчил илэрснээс 918.2 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж, залруулаагүй 1,221.6 сая төгрөгийн 75 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байсан зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, тайлант онтой харьцуулахад 35 хувиар буурсан байна.
3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 14 байгууллагад нийцлийн аудиттай холбоотой 1,180.9 сая төгрөгийн 21 зөрчил илэрсэн үүнээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 571.7 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 439.3 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн Дотоод аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байсан зөрчлийг арилгаж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.
4. Тус газар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан тайлан ирүүлэх цаглаварт хугацаанаас 2 хоног хоцроож тайлан ирүүлсэн зөрчлийг арилган тайлант онд давтан гаргаагүй байна.

Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	920,834.4	4	920,834.4	100.0
Нийт дүн	4	920,834.4	4	920,834.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах горим сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгах;
- НДЕГ-ын даргын 2025 оны А/314 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, 12 дугаар сарын 15-ны өдөр “Ай Ти Зон” ХХК-иас системийн эх кодыг хүлээн авч, 2,759.9 сая төгрөгийн өртөг бүхий программ, хангамжийг НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн байна. Тайлант онд системийн хөгжүүлэлтийн хүрээнд нийт 2,707.8 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь системийн өртгийн үндэслэлийг мэдээллийн технологийн аудитын хүрээнд нарийвчлан шалгаж, зарцуулсан зардал нь бодит гүйцэтгэл, техникийн үр дүнтэй уялдсан эсэхийг мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн шинжээч оролцуулан гүйцэтгэлийн аудитаар хамруулан үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

НДЕГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 493.2 сая төгрөгийн 28 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 669.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 16.7 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 155.1 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага хүргүүлэн, 497.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 37 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 669.6 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14.6 сая төгрөгөөр бага тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

5.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төвлөрүүлэн захирагч болон харьяа 33 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 17 байгууллагад дүгнэлт гаргаж, 16 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 17 харьяа байгууллагын 15 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 2 (НДЕГ, Увс аймгийн НДГ) байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,162.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 493.2 сая төгрөгийн 28 алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 16.7 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 155.2 сая төгрөгийн зөрчилд 17 албан шаардлага хүргүүлэн, 497.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 37 зөвлөмжийг өгсөн.

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 33 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,162.8 сая төгрөгийн 95 алдаа, зөрчил илэрснээс 493.1 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж, санхүүгийн тайлагналтай холбоотой 669.6 сая төгрөгийн 67 зөрчил илэрсэн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;” 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-д “Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 37.13.5-д “нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авах талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
1	НДЕГ	3	3,115.4	2	1,515.0	1	1,600.4	3	3,115.4				
2	Багануур дүүргийн НДГ	1	158.2	1	158.2			1	158.2				
3	Налайх дүүргийн НДГ	3	6,186.9	2	1,213.0	1	4,973.9	3	6,186.9				
4	Сонгинохайрхан дүүргийн НДГ	4	214,007.7			4	214,007.7	4	214,007.7				
5	Хан-Уул дүүргийн НДГ	2	171,963.0			2	171,963.0	2	171,963.0				
6	Чингэлтэй дүүргийн НДГ	1	6,099.4			1	6,099.4	1	6,099.4				
7	Баянхонгор аймгийн НДГ	1	3,255.1	1	3,255.1			1	3,255.1				
8	Баянхонгор аймгийн НДГ	1	1,277.7			1	1,277.7	1	1,277.7				
9	Булган аймгийн НДГ	4	35,300.0	4	35,300.0			4	35,300.0				
10	Говь-Алтай аймгийн НДГ	2	47,950.9			2	47,950.9	2	47,950.9				
11	Говьсүмбэр аймгийн НДГ	5	3,842.3			5	3,842.3	5	3,842.3				
12	Өмнөговь аймгийн НДГ	1	-	1	-			1	-				
	Дүн	28	493,156.6	11	41,441.3	17	451,715.3	28	493,156.6	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын санал дүгнэлт							Нийт зөрчлийн дүн		Үүнээс:							
		Үүнээс:									Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах	Хамрагдаагүй	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	НДЕГ-ТТЗ							1	-			1	-					
1	НДЕГ	1		1				7	156,309.2			5	53,382.0			2	102,927.2	
2	Багануур дүүргийн НДГ	1					1	5	4,221.7							5	4,221.7	
3	Багахангай дүүргийн НДГ	1					1	2	9,026.9							2	9,026.9	
4	Баянгол дүүргийн НДГ	1					1	2	-							2	-	
5	Баянзүрх дүүргийн НДГ	1					1	2	2,810.5							2	2,810.5	
6	Налайх дүүргийн НДГ	1					1	2	22,289.8							2	22,289.8	
7	Сонгинохайрхан дүүргийн НДГ	1					1	3	25,804.4	2	768.1					1	25,036.3	
8	Сүхбаатар дүүргийн НДГ	1					1	5	26,900.7			1	15,670.9			4	11,229.8	
9	Хан-Уул дүүргийн НДГ	1					1	2	2,467.0			1	2,357.1			1	109.9	
10	Чингэлтэй дүүргийн НДГ	1					1	7	78,730.8							7	78,730.8	
11	Архангай аймгийн НДГ	1	1					2	14,846.9			2	14,846.9					
12	Баян-Өлгий аймгийн НДГ	1	1					-	-									
13	Баянхонгор аймгийн НДГ	1	1					-	-									
14	Булган аймгийн НДГ	1	1					6	7,211.2	5	6,489.3	1	721.9					

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

15	Говь-Алтай НДГ	1					1	1	10,638.3							1	10,638.3	
16	Говьсүмбэр аймгийн НДГ	1	1					2	8,683.4			2	8,683.4					
17	Дархан-Уул аймгийн НДГ	1	1					-	-									
18	Дорноговь аймгийн НДГ	1					1	-	-									
19	Дорнод аймгийн НДХГ	1	1					1	23,784.9							1	23,784.9	
20	Дундговь аймгийн НДГ	1	1					1	56,276.5							1	56,276.5	
21	Завхан аймгийн НДГ	1	1					-	-									
22	Сүхбаатар аймгийн НДГ	1					1	-	-									
23	Орхон аймгийн НДГ	1	1					5	39,998.4	3	7,063.9	1	7,934.5			1	25,000.0	
24	Өвөрхангай аймгийн НДГ	1	1					-	-									
25	Өмнөговь аймгийн НДГ	1	1					3	69,492.1							3	69,492.1	
26	Сэлэнгэ аймгийн НДГ	1	1					2	18,497.5	1	1,799.5	1	16,698.0					
27	Төв аймгийн НДГ	1	1					1	31,981.9							1	31,981.9	
28	Увс аймгийн НДГ	1		1				2	32,505.6			2	32,505.6					
29	Ховд аймгийн НДГ	1					1	-	-									
30	Хөвсгөл аймгийн НДГ	1	1					-	-									
31	Хэнтий аймгийн НДГ	1					1	-	-									
32	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба	1					1	2	2,676.0	1	300.0	1	2,376.00					
33	Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төв	1					1	2	24,441.4	1	250.0					1	24,191.4	
Дүн		33	15	2	-	-	-	16	68	669,595.1	13	16,670.8	18	155,176.3	-	-	37	497,748.0

6.3 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар -ТТЗ	1	-			1	-				
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	4	3,107,473.0			4	3,107,473.0				
2	Багануур дүүргийн НДГ	1	-							1	
3	Багахангай дүүргийн НДГ	1	-							1	
4	Баянгол дүүргийн НДГ	2	-							2	
5	Баянзүрх дүүргийн НДГ	1	-							1	
6	Налайх дүүргийн НДГ	1	-							1	
7	Сонгинохайрхан дүүргийн НДГ	2	11,527.9							2	11,527.9
8	Говьсүмбэр аймгийн НДГ	1	-							1	
9	Сэлэнгэ аймгийн НДГ	1	-							1	
10	Төв аймгийн НДГ	1	-							1	
	Дүн	16	3,119,000.9			5	3,107,473.0			11	11,527.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1140/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/8/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 33 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,162,751,697.63 /нэг тэрбум нэг зуун жаран хоёр сая долоон зуун тавин нэгэн мянга зургаан зуун ерэн долоон/ төгрөгийн 95 алдаа, зөрчил илэрснээс 493,156,627.63 /дөрвөн зуун ерэн гурван сая нэг зуун тавин зургаан мянга зургаан зуун хорин долоон/ төгрөгийн алдааг залруулга хийлгэж, санхүүгийн тайлагналтай холбоотой 669,595,070.00 /зургаан зуун жаран есөн сая таван зуун ерэн таван мянга далан/ төгрөгийн 67 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;" 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:"; 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-д "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:"; 37.13.5-д "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Б.Ганхуяг/, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга /Б.Алтанцэцэг/, Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Батцэцэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1141/АД161139

Улаанбаатар хот

САГ - 2026/8/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 10 байгууллагад нийцлийн аудиттай холбоотой 3,119,000,900.00 /гурван тэрбум нэг зуун арван есөн сая есөн зуун төгрөг/ төгрөгийн 15 зөрчил илэрсэн үүнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,900,503,700.00 /хоёр тэрбум есөн зуун сая таван зуун гурван мянга долоон зуун/ төгрөгийн 2 албан шаардлага, архивын нэгж бүрдүүлэхтэй холбоотой 1 албан шаардлага, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 206,969,200.00 /хоёр зуун зургаан сая есөн зуун жаран есөн мянга хоёр зуун/ төгрөгийн 1 албан шаардлага, 835,900.00 /найман зуун гучин таван мянга есөн зуун/ төгрөгийн 4 зөвлөмж, мөн цалин хөлстэй холбоотой зөрчилд 10,692,000.00 /арван сая зургаан зуун ерэн хоёр мянган/ төгрөгийн 2 зөвлөмж, худалдан авах ажиллааг тайлагнаагүй зөрчилд 2 зөвлөмж, ахмадын сан байгуулж ажиллаагүй зөрчилд 3 зөвлөмж тус тус өгсөн. Энэ нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн Дотоод аудитын албанаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх";, 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх";, 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх";, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах";, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-д "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ";, 37.13.5-д "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Б.Ганхуяг/ Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дарга /Б.Алтанцэцэг/, Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Батцэцэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА